



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар

4/76

Улаанбаатар хот

Багшийн гүйцэтгэх ажлын
хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 тоот тогтоол, 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24, 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, шийдвэр, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоол, БСШУС-ын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 тоот захирамж, 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай” А/223 дугаар захирамж, МУИС-ийн Дүрмийн 4.3.1 дэх хэсэг, захиргааны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн өргөтгөсөн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж, улс даяар хөл хорио тогтоож, эрдэм шинжилгээний хурал, семинар, зөвлөгөөн, гадаад томилолт цуцлагдаж, нийгмийн бусад үйлчилгээ явагдахгүй болсонтой холбогдуулан 2019-2020 оны хичээлийн жилд багшийн гүйцэтгэх эрдэм шинжилгээний /Б цаг/, бусад ажил /В цаг/-ын багц цагийн ачааллыг тус тус 50 хувиар бууруулан тооцож, хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулсугай.

2. 2019-2020 оны хичээлийн жилийн төгсгөлд багш нарын цагийн гүйцэтгэлийг дүгнэхдээ хавсралтаар баталсан цагийн ноогдлын дагуу тооцохыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд /Д.Заяабаатар, Н.Баатарбилэг, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, С.Баттулга/, салбар сургуулийн захирал /Т.Энх-Амгалан/, Д.Алтанхуяг/ нарт тус тус даалгасугай.

3. Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх /Б1/ багц цагийн илүү цагийг тооцохдоо хавсралтад заасан хөнгөлсөн багц цагийн ачаалалд үндэслэн тооцохыг зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

3340300708

Захирлын 2020 оны 13 дугаар сарын 25-ны
өдрийн 476 дугаар тушаалын хавсралт



2019-2020 оны хичээлийн жилд багшийн гүйцэтгэх багц цагийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Сургалт "А"	Эрдэм шинжилгээ "Б"	Бусад ажил "В"
Профессор	12	5	2
Дэд профессор	13	4	2.5
Ахлах багш	15	3	2.5
Багш	16	2.5	2.5
Дадлагажигч багш	13	2	3.5